

**ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**

Үндэсний Аудитын газрын үйл ажиллагааны 2015 оны
төлөвлөгөөний дагуу хийсэн ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ,
НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТЫН ОРОН
НУТГИЙН ХЭМЖЭЭНД ХҮРЭХ ТҮВШИН
ТОДОРХОЙГҮЙ БАЙНА**

Зохион байгуулалтын нэгж: **ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН БАГ**

Аудитын код: **ҮАГ-ГАГ/2015/02-ГА-ХЭ**

Аудитын нэр: **Монгол улсын эдийн засаг,
нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн
чиглэлийн хэрэгжилт, үр дүн**

Өндөрхаан хот
2015 он

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТЫН ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ХҮРЭХ ТҮВШИН ТОДОРХОЙГҮЙ БАЙНА

ОРШИЛ ХЭСЭГ

Монгол улсын ЭЗН-ийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнд аудит хийхээр аймгийн ЗДТГ-ын дарга болон холбогдох мэргэжилтнүүд, Тэргүүлэх аудитор, аудитын менежер, шинжээч нар оролцсон уулзалтыг зохион байгуулж шаардагдах судалгаа, тайлан болон аудит хийхэд анхаарах асуулын талаар танилцуулж, тэдний саналыг сонслоо.

Аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн албан тушаалтнуудын ажил, үүргийн хуваарийн дагуу ЭЗН-ийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг нэгтгэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үүрэгтэй ХШҮ-ний тасгийн мэргэжилтэнд аудитад шаардлагатай материалын талаар дэлгэрэнгүй танилцуулсан.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасаг зарим зорилтын үр дүнг гаргахдаа нэгж байгууллагаас илүүлсэн тайланг бодит байдалтай нягтлан шалгаагүйгээс аудитын явцад биелэлтийн үнэлгээ өөрчлөгдөхийн зэрэгцээ улсын хэмжээний үндсэн чиглэлээс орон нутагт хэрэгжүүлэх зорилтыг тодорхой болгоогүйгээс шалтгаалж аймгийн хэмжээнд биелэлт гаргах зорилт орхигдох үндэслэл болж байна.

Монгол улсын ЭЗН-ийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 106 зорилт арга хэмжээний 27 зорилтыг хяналтанд авч биелэлтийг 90,3%-тай гаргасан байна.

АУДИТЫН ДҮН

Нэг. Монгол улсын ЭЗН-ийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээнээс орон нутагт хэрэгжүүлэх ажлыг тодорхойлон аймгуудад хүргүүлдэггүйгээс хэрэгжүүлэх ажил орхигдож байна.

- Үндсэн чиглэлд туссан заалтыг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой шийдвэр, зорилтыг ирүүлээгүй байна. Тухайлбал:
 - Улсын 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, шийдвэр ирүүлээгүй нь аймгийн хэмжээнд хамаарах 32 зорилтоос 20 буюу 62,5% нь л аймгийн үндсэн чиглэлд тусаагүй байна.
 - Харин яамдын сайд нарын Аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний хавсралтад орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ажил үйлчилгээ, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлаас үндсэн чиглэлийн зорилтод орсон заалтыг авах замаар аймагт хэрэгжих зорилтыг тодорхойлсон байна.
- Хэнтий аймагт Монгол улсын ЭЗН-ийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө гаргаагүй улмаар тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд аймаг, орон нутгийн оролцоо, чиг үүрэг, санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байдаг нь үр дүн, биелэлтэд нөлөөлж байна. Тухайлбал:

- Монгол улсын ЭЗН-ийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлээс аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой 32 зорилтоос 4 зорилтын биелэлтийг тооцоогүй орхигдуулсан байна.
- Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэхээр тусгагдсан боловч орон нутагт тендер зарлах, хяналт тавих эрх байхгүй тул гүйцэтгэлийн талаарх мэдээлэл аймагт хомс байхгүй байна.

Хоёр. Монгол улсын ЭЗН-ийг хөгжүүлэх үндсэн чиглэлээс түүвэрлэн авсан Хэнтий аймагт хэрэгжих 32 зорилт, арга хэмжээний 24 зорилт нь 70%-иас дээш биелэлттэй байна.

- Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэхээр хяналтанд авсан зорилтын хүрэх үр дүнг тодорхойлон биелэлтийг ханган ажилласан байна. Үүнд:
 - Айл өрхийн цахилгаан хангамжийг найдвартай болгох ажлыг 3 суманд хийгдэхээр төлөвлөж 5 суманд хийгдэж зорилтот түвшинд хүрсэн боловч үнэлгээг бууруулан үнэлсэн байна.
 - Монгол улсын ЭЗН-ийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үүднээс улсын төсвийн 6965,0 сая төгрөг, орон нутгийн төсвийн 1494,3 сая төгрөг, хувийн болон гадаадын хандив 214,6 сая төгрөг нийт 8673,9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтыг 17 зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд санхүүжүүлсэн байна.
 - Хэнтий аймагт хэрэгжүүлэхээр тусгагдсан 8 зорилт арга хэмжээний хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлээр хийлгэх буюу хөрөнгө шаардахгүй зохион байгуулалтын арга хэмжээ эзэлж байна.
- Дараахи зорилтуудын биелэлтийг гаргаагүй буюу гүйцэтгэл хангалтгүй байна. Үүнд:
 - Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож ажлыг орхигдуулсан, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, үндэсний байгаль, соёл, түүхийн өв газруудын хил хязгаарыг тогтоох ажил хийгдээгүй, улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээг өргөтгөх талаар хийсэн ажлын биелэлт байхгүй, хот суурингаас хөдөө орон нутагт шилжин суурьших, ажил эрхлэх санаачлагийг зээл, санхүүгийн дэмжлэг, урамшууллын бодлогоор дэмжих зэрэг зорилтуудын биелэлтийг тооцолгүй орхигдуулсан.
 - Эвдрэлтэй талбайг нөхөн сэргээх ажил бүрэн хийгдээгүй, төмс, хүнсний ногооны мекнакжуулсан талбайн хэмжээ зорилтот хэмжээнд хүрээгүй, жимс, жимсгэнэ тариалалтын талбай зорилтот хэмжээндээ хүрээгүй, түүх дурсгалын газрыг тэмдэгжүүлэх, аялал жуулчлалын аймгийн дэд хөтөлбөр боловсруулах, “Чингис хааны түүхэн дурсгал” цогцолборын ажил хангалтгүй, шинээр ажлын байртай болсон иргэн хангалтгүй, соёлын өвийг хамгаалах талаар ЦГ-тай хийх хэлцэл хийгдээгүй, сэргээн засварлах соёлын өвийн тоо зорилтод хүрээгүй, спортын аймгийн дэд хөтөлбөр боловсруулагдаж гаргаагүй, хил хамгаалах байгууллагад үзүүлэх хийлдэг завьны хөрөнгийг бүрэн шийдээгүй зэрэг ажлууд дутуу хийгдсэн байхад үнэлгээг өсгөн үнэлсэн байна.
 - Улсын хил хамгаалалтанд дэмжлэг үзүүлэхээр хилийн 0287-р ангид 5 ширхэг хийлдэг завьны хөрөнгийн асуудлыг бүрэн шийдвэрлэхээр төлөвлөсөн боловч 2015 оны үндсэн чиглэлд тусгасан боловч хөрөнгийн асуудлыг аймгийн хөрөнгө оруулалтад тусгаагүй байна.
 - Багийн спортыг дэмжих аймгийн дэд хөтөлбөр болон аялал жуулчлалын дэд хөтөлбөрүүдийг боловсруулах ажил удаашралтай, Дадал суманд түүх дурсгалт газрыг тэмдэгжүүлэх ажил эхлэл төдий, Өндөрхаан хот дахь “Чингис

хааны түүхэн дурсгал” цогцолборын ажлын гүйцэтгэгчийг шалгуулсан зэрэг ажлууд удаашралтай явагдаж байна.

Гурав. Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасаг Хэнтий аймагт хамааралтай зорилтуудын 29,6%-ийн хэрэгжилтийг өсгөн үнэлжээ.

- Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасагт нэгтгэгдсэн зорилт арга хэмжээний биелэлтэд тавих хяналт хангалтгүйгээс Монгол улсын ЭЗН-ийг 2014 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэлд Хэнтий аймагт хамааралтай 32 зорилт, арга хэмжээнээс 4 зорилтын биелэлтийг гаргаагүй, 8 зорилтын биелэлтийг ахиулан үнэлсэн, 1 зорилтын биелэлтийг бууруулан үнэлсэн байна.

ДҮГНЭЛТ

1. ЭЗН-ийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээнээс аймгийн түвшинд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг нэгдсэн байдлаар тодорхойлж өгдөггүйгээс аймгийн хэмжээнд биелэлт гаргах зорилт орхигдох үндэслэл болж байна.
2. Аймгийн түвшинд Монгол улсын ЭЗН-ийг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх талаар тодорхой бодлого байхгүйгээс аймгийн ЭЗН-ийг хөгжүүлэх тухайн жилийн үндсэн чиглэлд тусгадаггүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

ҮАГ-аас гаргах аудитын тайлангийн зөвлөмжид өгөх санал

- Монгол улсын ЭЗН-ийг хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тухайн орон нутгийн хүрэх түвшинг аймаг бүрээр тодорхойлж, ТЕЗ нарын аймгийн ЗД-тай байгуулах гэрээндээ тусгаж өгөх асуудлыг Засгийн газарт зөвлөх
- Орон нутагт хамааралтай зорилт, арга хэмжээг аймгийнхаа тухайн жилийн ЭЗН-ийн үндсэн чиглэлд хүрэх үр дүн, хугацаа, хөрөнгийн хамт тусган аймгийн ИТХ-аар батлуулдаг байх талаар нэгдсэн чиглэл өгөх,
- Тухайн жилийн Монгол улсын ЭЗН-ийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийн хэрэгжилт хангалтгүй аймгуудад арга хэмжээ авдаг байх,

Жич: Хавсралт №1 судалгаа нь орон нутгийн төвшинд хийгддэггүй ажил учир судалгааг бөглөөгүй.

Хавсралт №2 судалгааны хөрөнгө оруулалтын төлөвлөлт орон нутагт хийгддэггүй тул төлөвлөлтийн мэдээлэл байхгүй байна.

Тайлан бичсэн: Шинжээч

Д.Эрдэнэбилэг

ХАВСРАЛТ

Хавсралт №2: 2014 оны үндсэн чиглэлийн үйл ажиллагааны үр дүнгийн судалгаа,

Хавсралт №3: 2014 оны үндсэн чиглэлийн санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн судлагаа,

Судалгаа №1: Монгол улсын ЭЗН-ийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа

ХОЛБОГДОХ ГАЗРЫН САНАЛ БА ТАЙЛБАР

Ирүүлсэн санал	Тайлбар
----------------	---------

Тайлбар:

Албан тоотод дурьдсан
2 саналыг танилцуулгад
оруулсан болно.


**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
23119 Өндөрхаан, Хэнтий аймаг
Утас/Факс: 70-56-24-12
E-mail: Khenziaadlg@yahoo.com

2015.02.26 № 9/299
танай _____-ны № _____-т

☐ Санал хүргүүлэх тухай ☐

Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийж байгаа гүйцэтгэлийн аудитад аймгийн хэмжээнд хяналтандаа авч хэрэгжүүлж байгаа зорилт арга хэмжээний 2014 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтийн тайланг, холбогдох судалгааны хамт хүргүүлээ.

Улсын Их Хурлаас үндэсний хөтөлбөр батлах болон салбарын бодлогыг тодорхойлж, яамнаас чиглэл өгч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний зорилт, заалтыг яамны түвшинд хэрэгжүүлнэ гэж тооцож, аймгийн хэмжээнд хяналтанд аваагүй учир хэрэгжилт тооцоогүй болно.

Тус бодлогын баримт бичигтэй холбогдуулан дараах саналыг хүргүүлж байна.

Үүнд:

1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг зөвхөн яамны түвшинд хэрэгжүүлэхээр оруулсныг аймгуудын хүрээнд хэрэгжилт тооцох зорилтыг тодорхой болгож оруулах.
2. Засгийн газар, яамдаас аймгийн Засаг даргатай болон салбар агентлагуудын дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тухайн зорилтыг хэрэгжүүлэхээр улсын төсвөөс батлагдсан төсвийн хуваарилалтыг бодлогын баримт бичгийн заалт тус бүрээр тусган, аймгийн түвшинд хэрэгжилтийг тооцох шалгуур үзүүлэлтийг тодорхой болгон оруулах


ДАРГА  М.БОЛД

03 073